



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.



Төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэж, холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Тайланг бэлтгэсэн:
Сэлэнгэ аймаг
дахь Төрийн
аудитын газар

Тэргүүлэх аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор

С.Бат-Эрдэнэ

Шинжээч

Ж.Цогт

2017 оны 06 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
7036-2442 дугаарын
утас, 7036-3040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ
аймгийн Сүхбаатар
сум аймгийн ЗДТГ-
ын байрны
өргөтгөлд

Агуулга

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Хоёр. Үндсэн мэдээлэл
Гурав. Аудитын дүн

Бүлэг 1: Чиг үүрэг, зорилго, зорилтоо үр нөлөөтэй хэрэгжүүлж байна уу?

1.1. Стратеги болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, үр дүнгийн гэрээ байгуулан, дүгнүүлж байна уу?

1.2. Дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн үү?

Бүлэг 2: Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа үр дүн, арвилан хэмнэлттэй байна уу?

2.1. Орлого, зардлыг үндэслэлтэй төлөвлөж, батлуулсан уу?

2.2. Батлагдсан төсөв, хөрөнгийг үр дүнтэй, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу?

2.3. Төрийн өмч, хөрөнгийн бэлтгэн нийлүүлэлт, ашиглалт, хамгаалалт үр дүн, үр нөлөөтэй байна уу?

Бүлэг 3: Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөө бүхий дотоод хяналт хийгдэж байна уу?

3.1. Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөөтэй байна уу?

3.2. Шилэн дансны цахим санд холбогдох мэдээллүүдийг байршуулж, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж байна уу?

Илрүүлсэн зөрчил

Аудитын дүгнэлт

Зөвлөмж

Хавсралтууд

Холбогдох байгууллагын санал

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГА	Гүйцэтгэлийн аудит
ХБНГУ-	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЗГ	Засгийн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.Аудитын нэр: Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны үр дүн.

2.Аудитын код: СЭА-2016/04-ГА

3.Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

4.Аудитын зорилт:

Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг Аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Чиг,үүрэг ,зорилго, зорилтоо үр нөлөөтэй хэрэгжүүлж байна уу?
2. Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа үр дүн, арвилан хэмнэлттэй байна уу ?
3. Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөө бүхий дотоод хяналт хийгдэж байна уу?

5.Аудитын хамрах хүрээ:

Аудитаар Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2015, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, түүний биелэлтийн талаарх илтгэх хуудас, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтууд, журнал, ерөнхий дэвтэр болон холбогдох бусад баримт, материалуудыг хамруулан шалгав.

6.Аудитын арга зүй:

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журам"-ыг мөрдөж Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал, нягтлан бодогч, эд хариуцагч, сургалтын менежер, багш, ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, тодруулга авах, байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

7.Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой уялдуулан дараах хууль, эрхийн актуудыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Төрийн аудитын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Мэргэжлийн боловсролын тухай хууль
- Бусад холбогдогдох хууль, дүрэм, журам, шийдвэрүүд

8. Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, шинжээч Ж.Цогт нар 2016 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

9.Үндсэн мэдээлэл:

Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь 1972 онд Техник мэргэжлийн 25 дугаар сургууль нэртэйгээр анх байгуулагдсан бөгөөд 1982 онд Ойн техник мэргэжлийн сургууль, 1992 онд шаталсан сургалттай сургалттай үйлдвэрлэлийн төв, 2002 онд Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болон өргөжин зохион байгуулагдсан байна.

Өнөөгийн байдлаар Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас гаргасан квотын дагуу 2.5 болон 1 жилийн сургалтад “барилгын засал чимэглэл, атомашины засварчин, нарийн бичгийн дарга-албан хэргийн ажилтан, гагнуурчин, барилгын цахилгаанчин, тогооч, ойжуулагч, оёмол бүтээгдэхүүний оёдолчин зэрэг мэргэжлүүдээр элсэлт авч 300 гаруй суралцагсад, 53 багш, ажиллагсадтайгаар “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэдлэг, чадвар, хандлаганд тулгуурласан үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх тэргүүлэх сургууль байхад оршино” гэсэн эрхэм зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

БҮЛЭГ:1

Чиг үүрэг, зорилго, зорилтоо үр нөлөөтэй хэрэгжүүлж байна уу?

Стратеги төлөвлөгөөнд тусгасан хөтөлбөр, арга хэмжээг жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах замаар хэрэгжүүлж, холбогдох байгууллагуудад тайлагнасан байна.

1.1 2015 оны үр дүнгийн гэрээг хичээлийн жилээр байгуулсан боловч дүгнүүлээгүй бөгөөд 2016 оны үр дүнгийн гэрээг “хангалтгүй” үнэлгээтэй дүгнүүлсэн байна.

Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг 2014-2017 он хүртэл хөгжүүлэх талаар баримтлах, бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон 3 бүлэг бүхий стратеги төлөвлөгөөг 2014 онд боловсруулан мөрдөж байгаа бөгөөд уг стратеги төлөвлөгөөнд тусгасан хөтөлбөр, арга хэмжээг жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах замаар хэрэгжүүлж ирсэн байна.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирлаар ажиллаж байсан Д.Очирбат нь төсвийн ерөнхийлөн захирагч буюу Хөдөлмөрийн сайдтай 2015 оны үр дүнгийн гэрээг 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2015 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хичээлийн жилээр байгуулж байсан бол 2016 оны үр дүнгийн гэрээг 2016 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр байгуулж, баталгаажуулсан байна.

Аудитаар, төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээ, түүний биелэлтийг тулган баталгаажуулахад 2014-2015, 2015-2016 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайлан нь файл хэлбэрээр, өөрөөр хэлбэл баталгаажаагүй байдлаар хадгалагдаж байгаа боловч 2015 оны төсвийн жилээр байгуулсан үр дүнгийн гэрээ, түүнийг дүгнэсэн биелэлтийн тайлан нь архивлагдаж, хадгалагдаагүй байна.

2016 оны үр дүнгийн гэрээг төсвийн ерөнхийлөн захирагч 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр дүгнэж, гэрээний хэрэгжилтийг хангалтгүй гэж үзэж, F үнэлгээ өгсөн байна.

2016 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэсэн үнэлгээ

хүснэгт №-1

Гэрээний үзүүлэлт	Өгвөл зохих оноо	Өгсөн оноо /дундаж оноо /
Нийт арга хэмжээний биелэлт	0-30	17.6
Тусгай арга хэмжээний биелэлт	0-40	29.6
Манлайллын зорилтын биелэлт	0-30	11.8
Нийт	0-100	59,0

Төсвийн шууд захирагчийн “Үр дүнгийн гэрээ”-г хичээлийн жилээр байгуулж, жилийн эцэст 1 удаа дүгнэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 40 дугаар зүйлийн 40.1 –д “Төсвийн шууд захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна”, 40.3-д “ үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн удирдах зөвлөл нь сургуулийн үйл ажиллагааны тайланг хэлэлцээд 2015-2016 оны хичээлийн жил, 2016 оны жилийн эцсийн үйл ажиллагааг 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 05, 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 05 дугаар тогтоолуудаар “хангалттай сайн” гэж дүгнэсэн боловч ямар шалгуур үзүүлэлтээр, хэрхэн яаж дүгнэсэн нь зөвлөлийн

хурлын тэмдэглэл болон бусад баримт, материалаар баталгаажуулж, өөрөөр хэлбэл хийсвэр байдлаар дүгнэгдсэн байна.

1.2 Төлөвлөсөн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж, холбогдох байгууллагуудад тайлагнаж байна.

Хөдөлмөрийн сайдтай байгуулсан 2014-2015 оны хичээлийн жилийн үр дүнгийн гэрээнд 8 зорилтын хүрээнд 102 арга хэмжээг, 2016 оны үр дүнгийн гэрээнд 9 зорилтын хүрээнд 110 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсний дагуу үйл ажиллагаа явуулж иржээ.

Тус МСҮТ нь Боловсролын тухай багц хууль, Хөдөлмөрийн яамнаас гаргасан дүрэм, журам, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу танхимын сургалтыг 1 жилээр, мэргэжлийн сургалтуудыг 2.5 жилээр, зохион байгуулж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны 2009 оны 2001/21 дугаар тусгай зөвшөөрлөөр гагнуурчин, барилгын цахилгаанчин, авто машины засварчин, оёмол бүтээгдэхүүний оёдолчин, барилгын сантехникч, ойжуулагч, барилгын өрөг угсрагч, барилгын засал чимэглэл, нарийн бичгийн дарга, бичиг хэргийн ажилтан зэрэг нийт 10 мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулах эрх олгосноос тайлант жилүүдэд барилгын сантехникчээс бусад мэргэжлээр элсэлт авч сургалт явуулсан байна

2014-2016 оны суралцагсдын тоог хичээлийн жилээр харуулбал:

хүснэгт №2

эргэжлийн индекс	Мэргэжлийн нэр	2014-2015 он					2015-2016 он					2016-2017 он				
		Нийт	Мэргэжлийн боловсрол			Мэргэжлийн сургалт 1 жилийн сургалт	Нийт	Мэргэжлийн боловсрол			Мэргэжлийн сургалт 1 жилийн сургалт	Нийт	Мэргэжлийн боловсрол			Мэргэжлийн сургалт 1 жилийн сургалт
			I	II	III			I	II	III			I	II	III	
7123-20	Барилгын засал чимэглэлч	50	13	23	14		47	22	10	15		34	22		12	
5120-11	Тогооч	37	20		17		47	30	17	0		45	18	15	12	
8211-20	Автомашинны засварчин	47	27	20			60	15	26	19		55	15	15	25	
7112-14	Гагнуурчин	49	19	17	13		52	19	17	16		35		18	17	
4120-11	Нарийн бичгийн дарга албан хэргийн ажилтан	60	12	20	7	21	79	47	14	18		52	25	12	15	
7411-12	Барилгын цахилгаанчин											36	36			
7112-19	Барилгын өрөг угсрагч	9			9											
7533-28	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин											20	20			
7112-19	Ойжуулагч						12	12				9		9		
	Нийт дүн	252	91	80	60	21	297	145	84	68		286	136	69	281	

Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас баталсан квотыг үндэслэн 9 төрлийн мэргэжлээр 1 болон 2.5 жилийн сургалтад 2014-2015 оны хичээлийн жилд 252, 2015-2016 оны хичээлийн жилд 297, 2016-2017 оны хичээлийн жилд 281 суралцагчийг хамруулан сургалтын үйл ажиллагаа явуулж иржээ.

Сүүлийн 3 жилийн элсэгчдийн тоог хүснэгтээр харуулбал:

хүснэгт №3

Мэргэжлийн төрөл	2014-2015 оны хичээлийн жил		2015-2016 оны хичээлийн жил.		2016-2017 оны хичээлийн жил.	
	квот	элсэлт	квот	элсэлт	квот	элсэлт
Мэргэжлийн боловсрол 2.5 жил	120	91	90	73	125	15
Мэргэжлийн сургалт 1 жил	30	75	70	112	45	121
Нийт	150	156	160	185	170	136

Хүснэгтээс харахад 2,5 жилийн сургалтад элсэгчдийн тоо жил ирэх тутам буурах хандлагатай байгаа бол 1 жилийн сургалтын элсэгчид жил бүр нэмэгдснээс нийт дүнгээр 2014-2015 оны хичээлийн жилийн элсэлт 104 хувийн, 2015-2016 оны хичээлийн жилийн элсэлт 116 хувийн, 2016-2017 оны элсэлт 80 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

2015-2016 оны хичээлийн жилд Хилийн цэргийн 0101–р ангитай хамтран ажиллаж, барилгын засал чимэглэлийн ангид 21, барилгын цахилгаанчны ангид 20 хугацаат цэргийн албан хаагчдыг, 2016-2017 оны хичээлийн жилд барилгын засал чимэглэлийн мэргэжлээр 14, цахилгаанчны мэргэжлээр 19, гагнуурчны мэргэжлээр 22 зэрэг нийт 55 хугацаат цэргийн албан хаагчдыг мэргэжлийн сургалтад хамруулж төгсгөсөн байна.

2014-2016 оны нийт төгсөгчдийг хичээлийн жил тус бүрээр харуулбал:

хүснэгт №4

Мэргэжлийн индекс	Мэргэжлийн нэр	2014-2015			2015-2016		2016-2017	
		Нийт төгсөгч	Үүнээс		Нийт төгсөгч	Мэргэжлийн боловсрол	Нийт төгсөгч	Мэргэжлийн боловсрол
			Мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт				
7123-20	Барилгын засал чимэглэлч	14	14		32	32	12	12
8211-20	Автомашинны засварчин	0	0		19	19	15	15
7112-12	Барилгын өрөг угсрагч	9	9					
7112-14	Гагнуурчин	13	13		16	16	17	17
4120-11	Нарийн бичгийн дарга, албан хэргийн ажилтан	22	6	16	42	37	15	15
5120-11	Тогооч	16	16		10	10	12	12
7411	Барилгын цахилгаанчин				21	21		
	Нийт	74	58	16	140	140	71	71

2014-2015 оны хичээлийн жилд 74 , 2015-2016 оны хичээлийн жилд 140, 2016-2017 оны хичээлийн жилд 71 оюутанг 7 мэргэжлээр тус тус төгсгөсөн байна.

Төгсөгчдийн ажил эрхлэлтийн талаарх судалгаанаас харахад 2016 оны төгсөгчдийн 46.9 хувь нь ажил эрхэлж байгаа бол 26.3 хувь нь үргэлжлүүлэн суралцаж , 26.8 хувь нь ажил эрхлээгүй гэсэн үр дүн гарсан байна.

БҮЛЭГ:2

Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа үр дүн, арвилан хэмнэлттэй байна уу?

Батлагдсан төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэж, зарим зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.

2.1 Төсвийн орлого, зарлагыг урьд оны гүйцэтгэл болон байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн байна.

Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хүрээний мэдэгдлийг 3 жилээр, дараа жилийн төсвийн төслийг жил бүр боловсруулан Хөдөлмөрийн яаманд хүргүүлж, хянуулсан байна.

ЗГ-ын 2012 оны 94 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар “ Мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив”-ыг 236.2 мянган төгрөгөөр, 4 дүгээр хавсралтаар “ мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг Сэлэнгэ аймагт 580.2 мянган төгрөгөөр тогтоосныг үндэслэн 2015, 2016 оны хувьсах зардал, төсвийн төслийг боловсруулсан байна. Төсвийн төсөлд суралцагсдын тоог 2015 онд 360 хүүхдээр, 2016 онд 330 хүүхдээр төлөвлөсөн бол төсвийн ерөнхийлөн захирагчаас 2015 онд 231, 2016 онд 295 хүүхдээр хянаж, төсвийг баталсан байна.

Дотуур байрны хүүхдийн тоог 2015 онд 75 хүүхдээр, 2016 онд 60 хүүхдээр төлөвлөснийг 60 хүүхдээр хянаж, баталсан байна. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг ЗГ-ын “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” 2012 оны 106 дугаар тогтоолын 3-д “Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдарх нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 2315 төгрөгөөр” тогтоосныг үндэслэн төлөвлөсөн байна.

Тогтмол зардлыг урьд оны төсвийн гүйцэтгэл болон нийлүүлэгч байгууллагын үнэ, өртгийг үндэслэн төлөвлөж ирсэн байна.

МСҮТ-өөс боловсруулсан 2015, 2016 оны төсвийн төслийг хүснэгтлэн
харуулбал:

хүснэгт №5

/мянган төгрөг/

Хөтөлбөрийн ангилал	2015 он	2016 он	Зөрүү
Нийт зардлын дүн	948,666.9	866,042.7	82,624.20
Сургалтын стандарт, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	208,092.0	206,169.4	1,922.60
Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	480,951.2	581,922.1	(100,970.90)
Дотуур байрны сурагчдыг хоолоор хангах	48,441.4	38,753.1	9,688.30
Дотуур байрны стандарт, төлөвлөгөө	24,913.1	27,759.5	(2,846.40)
Суралцагчдад сар тутам олгох тэтгэлэг	135,000.0	-	135,000.00
Нийгмийн баталгааг хангах	51,269.2	11,438.6	39,830.60
Зардлын санхүүжүүлэх эх үүсвэр	948,666.9	866,042.7	82,624.20
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4100	4100	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35387.8	0	35,387.80
Улсын төсвөөс санхүүжих	909179.1	861942.7	47,236.40
Ажиллагсад бүгд	53	53	-
Удирдах ажилтан	1	1	-
Гүйцэтгэх ажилтан	24	36	(12.00)
Үйлчлэх ажилтан	28	16	12.00
Суралцагсад	360	330	30.00

Төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс 2015 оны төсвийг төсвийн төсөлд тусгасан дүнгээс 173,056.3 мянган төгрөгөөр бага буюу 775,610.7 мянган төгрөгөөр хянасан бөгөөд тайлант жилд 3 удаа өөрчлөлт оруулж, эцсийн байдлаар 777,918.9 мянган төгрөгөөр тодотгож баталсан байна.

МСҮТ-ийн боловсруулсан төсвийн төсөлд тусгасан зардлын дүнг анхны батлагдсан төсвийн зардлын бүлгийн дүнгээр харьцуулж үзэхэд суралцагсдын тэтгэлгийн зардлыг 135,000.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардлыг 11,755.5 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 5,365.0 мянган төгрөгөөр, эм хоолны зардлыг 9,067.2 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах, урсгал засварын зардлыг 12,585.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 5,976.7 мянган төгрөгөөр, биеийн тамир уралдаан, тэмцээн, сургалт хурал зөвлөгөөний зардлыг 10,032.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 10,465.5 мянган төгрөгөөр зэрэг нийт **200,246.9** мянган төгрөгөөр танаж, цалин, НДШ-ийн зардлыг 18,544.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 600.3 мянган төгрөгөөр, хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлыг 8,045.9 мянган төгрөгөөр зэрэг нийт **27,190.6** мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. /дэлгэрэнгүйг хавсралт № 2-т үзүүлэв /

2016 оны төсвийг төсвийн төсөлд тусгасан дүнгээс 124,206.3 мянган төгрөгөөр бага буюу 741,836.4 мянган төгрөгөөр хянасан бол тайлант онд мөн 3 удаа өөрчлөлт оруулж, эцсийн байдлаар 774,947.0 мянган төгрөгөөр тодотгосон байна.

2016 оны төсөвт цалин, НДШ-ийн зардлыг 30,420.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 1,103.1 мянган төгрөгөөр, эм, хоолны зардлыг 12,912.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 12,135.8 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах, урсгал засварын зардлыг 60,398.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 5,808.7 мянган төгрөгөөр, төлбөр хураамж, биеийн тамирын уралдаан тэмцээн, сургалт, хурал зөвлөгөөний зардлыг 10,000.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 26.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 4,858.3 мянган төгрөгөөр зэрэг нийт **139,777.4** мянган төгрөгийн зардлыг бууруулж баталсан бол хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардлыг **15,571.1** мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. /дэлгэрэнгүйг хавсралт № 2-т үзүүлэв /

Тайлант жилүүдийн төсвийн төслийг боловсруулахдаа суралцагсдын тоог бодит хэмжээнээс өсгөж тооцсоноос нийт зардлыг хэт өндрөөр төсөвлөж, хүргүүлснийг төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд танаж, баталсан байна.

2.2 Батлагдсан төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэж, цалингийн зардлаас бусад зардалд гүйлгэн зарцуулсан байна.

2015 онд улсын төсвөөс 698,117.9 мянган төгрөгийн санхүүжилтийн, өөрийн орлогоос 3,384.6 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын сангаас 11,234.9 мянган төгрөгийн, сургалтын төрийн сангаас 64,260.9 мянган төгрөгийн зэрэг нийт 776,998.4 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 750,397.4 мянган төгрөгийг зарцуулан, 26,601.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. /дэлгэрэнгүйг хавсралт № 1-д үзүүлэв /

2016 онд улсын төсвөөс 739,988.6 мянган төгрөгийн санхүүжилтийн, өөрийн орлогоос 3,914.1 мянган төгрөгийн, сургалтын төрийн сангаас 7,025.9 мянган төгрөгийн, ХБНГУ-ын мэргэжлийн боловсролыг дэмжих GIZ PAO төслөөс 6,635.3 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын сангаас 7,553.4 мянган төгрөгийн зэрэг нийт 765,117.4 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн бол гүйцэтгэлээр 715,223.4 мянган төгрөгийг зарцуулж, 49,893.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. /дэлгэрэнгүйг хавсралт № 2-т үзүүлэв /

2015, 2016 оны төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

хүснэгт №6

/мянган төгрөг/

Зардлын төрөл	2015 он	Дүнд эзлэх хувь	2016 он	Дүнд эзлэх хувь
Цалин, НДШ-ийн зардал	474,523.0	61.1	455,801.9	60.2
Тогтмол зардал	101,095.6	13.0	120,000.6	15.8
Эм, хоолны зардал	22,893.5	2.9	25,603.9	3.4
Эд хогшил, худалдан авах зардал, урсгал засварын зардал	7,738.4	1.0	7,842.3	1.0
Хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардал	20,494.7	2.6	31,125.2	4.1
Бусад бараа үйлчилгээний зардалд	18,725.9	2.4	46,362.2	6.1

Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал	29,430.0	3.8	13,908.0	1.8
Суралцагсдын тэтгэлгийн зардал	64,261.0	8.3	7,025.9	0.9
Төвлөрүүлэх шилжүүлэг	26,601.0	3.4	49,893.9	6.6
Жирэмсэн, амаржсны болон ХЧТА-ы тэтгэмж	11,234.9	1.4	-	
Нийт зардлын дүн	776,998.0	100.0	757,564.0	100.00

2015, 2016 оны төсвийн гүйцэтгэлийг бүтцээр нь дунджаар авч үзэхэд цалин, НДШ-ийн зардалд 61,0 хувийг, тогтмол зардалд 14.4 хувийг, эм, хоолны зардалд 3.1 хувийг, хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардалд 3.4 хувийг, бусад бараа үйлчилгээний зардалд 4.3 хувийг, тэтгэмж, урамшууллын зардалд 2.8 хувийг, суралцагсдын тэтгэлгийн зардалд 4.6 хувийг, жирэмсэн, амаржсаны болон ХЧТА-ы тэтгэмжийн зардалд 1.4 хувийг зарцуулж, 5.0 хувийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсөвтэй харьцуулж үзэхэд 2015 онд цалин, НДШ 35,225.6 мянган төгрөгөөр, тогтмол зардал 14,592.4 мянган төгрөгөөр, эм, хоол, зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал 23,020.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 8,052.0 мянган төгрөгөөр, урсгал засварын зардал 261.6 мянган төгрөгөөр, томилолтын зардал 634.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 6,208.5 мянган төгрөгөөр, хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардал 4,476.2 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардал 12,166.4 мянган төгрөгөөр зэрэг нийт 104,637.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэн харагдаж байна. Гэвч энэ нь төсвийн бодит хэмнэлт биш бөгөөд Сангийн яамнаас 59,706.8 мянган төгрөгийн зардлын зарцуулах эрхийг нээж өгөөгүй, 18,239.9 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосноос шалтгаалсан байна.

Төсвийг зохистой удирдаагүй, төсөвт холбогдох зохицуулалт хийлгээгүйгээс жилийн эцэст 26,601.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлж, **29,039.5** мянган төгрөгийн өр төлбөртэй тайлагнагдсан байна.

2016 онд цалин, НДШ-ийн зардлыг 33,904.2 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 333.9 мянган төгрөгөөр, эм, хоолны зардал 9,389.8 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 526.0 мянган төгрөгөөр, эд, хогшил худалдан авах болон урсгал засварын зардал 5,729.6 мянган төгрөгөөр, томилолтын зардал 10.4 мянган төгрөгөөр зэрэг нийт 49,893.9 мянган төгрөгийн зардал хэмнэгдснийг төсөвт төвлөрүүлсэн байна.

2016 онд төсвийг зохистой удирдаагүйгээс болон 2014 онд төсөвт тусгагдаж, батлагдаагүй хөрөнгө худалдан авсны улмаас жилийн эцэст 5,074.4 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 –д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчиж байна.

Тайлагнагдсан өр, төлбөрийг дансдаар харуулбал:

хүснэгт №7

/ мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2015 он	2016 он
1	ХХОАТ	144.7	74.4
2	Бичиг хэргийн	770.2	
3	Түлш халаалтын	4,431.2	
4	Цэвэр бохир усны	2,639.4	
5	Тээвэр шатахууны	2,048.6	
6	Шуудан холбооны	1,030.6	
7	Томилолтын	156.0	
8	Байгууллагад төлөх өглөг	10,251.8	5,000.0
9	Хувь хүмүүстэй хийх тооцоо	7,567.0	
	Нийт	29,039.5	5,074.4

Төсвийн тухай хуулийн дагуу төсвийг зохистой удирдаж, зохицуулалт хийх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бол дээрх өглөгийг үүсгэхгүй байх боломж байсан байна.

Аудитаар үйл ажиллагааны зардлыг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ❖ 2016 онд суралцагсдаас хандивласан 1,867.5 мянган төгрөгийг кассаар бэлэн авч зарцуулсан байна.
- ❖ Цалингийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой нийт 3,212.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Харьяа яамнаас МСҮТ-ийн захиралд олгох ур чадварын нэмэгдлийг 15 хувиар олгохоор тогтоосон байхад удирдах зөвлөлийн шийдвэрээр 5 хувиар илүү тооцож, 458.9 мянган төгрөгийн цалин олгосон,
- Хөдөлмөрийн сайдын “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дүрэм, бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” 2016 оны А/30 дугаар тушаалыг зөрчиж, байгууллагын бүтэц, орон тоонд батлагдаагүй соёлын арга зүйч албан тушаалд Д.Тунгалагийг захирлын 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Б/27 дугаар тушаалаар томилон ажиллуулж, нийт 2,753.2 мянган төгрөгийн цалин, шимтгэлийн зардал гаргасан байна.

- ❖ Батлагдсан цалингийн зардлаас бусад зардалд нийт 9,367.6 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна. Үүнд:

- Багш, ажилтнуудад олгосон цалингийн урьдчилгааг кассаар бэлэн авч, 2015 онд 1,724.0 мянган төгрөгийг, 2016 онд 2,340.0 мянган төгрөгийг хичээл, үйлдвэрлэлийн дадлага, тээвэр шатахуун, төрийн өмнөөс гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардалд,
- Цалингийн зардлаас нэг удаагийн тэтгэмжийн зардалд буюу түлээ, нүүрсний хөнгөлөлтөд 2015 онд 2,320.0 мянган төгрөгийг, 2016 онд 2,450.0 мянган төгрөгийг, 2016 онд төрийн өмнөөс гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 533.6 мянган төгрөгийг зэрэг нийт 5,303.6 мянган төгрөгийг,

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5-р зүйлийн 5.1, 5.5 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

Ур чадварын нэмэгдлийг олгохдоо холбогдох журамд заасны дагуу тайлант хугацаа бүрээр ажлын үзүүлэлтийг нь дүгнэж, үр дүнг нь харгалзан үзэлгүйгээр, сард 20-24 ажилтанд 10-20 хувиар хавтгайруулан олгож байгаа нь ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 2 дахь, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 тушаалын 5 дахь заалтуудыг зөрчиж байна.

Захирлын 2016 оны 09-р сарын 01-ний өдрийн Б/19 дугаар тушаалаар нягтлан бодогч Л.Баасанжавыг эдийн засгийн хичээлийн цагийн багшаар давхар ажиллуулж, 1,468.8 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь бакалавр, түүнээс дээш зэрэгтэй, эсхүл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна”, Хөдөлмөрийн сайдын 2016 оны 04-р сарын 18-ны өдрийн А/93 тушаалын нэгдүгээр хавсралт “Багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Багшлах эрхгүй багшийг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад багшаар ажиллуулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

2.3 Өмч хөрөнгийн бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, ашиглалт хэвийн байгаа боловч хичээл, үйлдвэрлэлийн зардлаас худалдан авсан бараа материалуудын орлого, зарлагыг материалын дансанд бүртгээгүй байна.

Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирлын 2015 оны А/10, А/26, 2016 оны А/21, А/26 дугаар тушаалуудаар хагас жилийн болон жилийн эцсийн хөрөнгийн тооллогын комиссыг 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон, гүйцэтгүүлж, хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг данс бүртгэлд бүрэн тусгаж, үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Бараа, материалын хөдлөл, өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

хүснэгт №8

/мянган төгрөг/

Дансны нэр	2015.12.31				2016.12.31		
	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
Тусгай зориулалтын материал	142,324.5	19,011.1	150.1	161,185.5	35,209.3	66,150.8	130,244.0
Эм боох материал	-	50.0	50.0	-	821.6	134.6	687.1
Бичиг хэргийн материал		2,869.3	2,710.3	159.0	4,060.0	2,582.0	1,637.0
Аж ахуйн материал	8,841.7	3,204.0	4,862.7	7,183.0	8,589.8	3,019.3	12,753.5
Сэлбэг хэрэгсэл		1,043.3	1,043.3	-	2,923.3	2,923.3	-
Түлш, шатах тослох материал	8,740.1	40,691.7	45,976.0	3,455.8	46,409.1	35,892.6	13,972.2

Засварын материал	8,192.5	20,096.8	23,372.8	4,916.5	8,222.9	6,651.7	6,487.7
Хүнсний материал	194.5	23,366.0	23,238.5	322.1	25,270.5	25,122.6	470.0
Баглаа боодол		1,892.1	986.6	905.5	1,259.0	1,743.8	420.7
Бусад	160,640.3	2,436.5	36,234.4	126,842.4	51,648.9	87,631.0	90,860.3
Нийт дүн	328,933.6	114,660.8	138,624.5	304,969.9	184,414.4	231,851.8	257,532.5

Бараа материалын үлдэгдлийг өмнөх онтой харьцуулахад 2015 онд 7.2 хувиар буюу 23,963.7 мянган төгрөгөөр, 2016 онд 15.5 хувиар буюу 47,437.4 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

2015 онд төсвийн хөрөнгөөр 4,990.0 мянган төгрөгийн, Хөдөлмөрийн яамны хөрөнгө оруулалтаар 82,814.5 мянган төгрөгийн, олон улсын байгууллагын хандив тусламжаар 51,831.1 мянган төгрөгийн, хичээл үйлдвэрлэлийн дадлагын хичээлээр хийсэн бүтээгдэхүүнээс 212.5 мянган төгрөгийн, бараа материалын данснаас шилжүүлж бүртгэсэн 36,090.6 мянган төгрөгийн зэрэг нийт 175,938.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн орлого бүртгэсэн байна.

2016 онд төсвийн хөрөнгөөр 4,300.0 мянган төгрөгийн, олон улсын байгууллагын хандив тусламжаар 136,416.1 мянган төгрөгийн бараа материалын данснаас шилжүүлж бүртгэсэн 144,230.7 мянган төгрөгийн, хөрөнгийн дахин үнэлгээний өсөлтөөр 2,743.7 мянган төгрөгийн зэрэг нийт 287,698.5 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэсэн бөгөөд хасагдсан хөдөлгөөн хийгдээгүй байна.

Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

хүснэгт №9

/мянган төгрөг/

Дансны нэр	2015.12.31			2016.12.31	
	Эхний үлдэгдэл	Орлого	Эцсийн үлдэгдэл	Орлого	Эцсийн үлдэгдэл
Барилга байгууламж	3,764,115.4		3,764,115.4		3,764,115.4
Автотээврийн хэрэгсэл	138,265.7		138,265.7		138,265.7
Тоног төхөөрөмж	804,988.4	125,217.6	930,206.0	99,184.3	1,029,390.3
Тавилга хэрэгсэл	108,670.7	50,368.6	159,039.3	97,094.8	256,134.1
Номын фонд	15,121.6	140.0	15,261.6	91,419.4	106,681.0
Бусад үндсэн хөрөнгө	7,731.5	212.5	7,944.0		7,944.0
Биет бус хөрөнгө	23,413.5		23,413.5		23,413.5
Нийт дүн	4,862,306.8	175,938.8	5,038,245.5	287,698.5	5,325,944.0

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг өмнөх онтой харьцуулахад 2015 онд 3.6 хувиар, 2016 онд 5.7 хувиар өссөн байна.

Аудитаар, хөрөнгө, бараа материалын зарцуулалтыг анхан шатны баримт руу хөөн шалгахад хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас сургалтын үйл ажиллагаанд худалдан авсан 2015 онд 6,086.0 мянган төгрөгийн, 2016 онд 16,656.6 мянган төгрөгийн зэрэг нийт 22,742.6 мянган төгрөгийн бараа материалын орлого,

зарлагыг бараа материалын дансаар дамжуулж бүртгээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх “Төсвийн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.21-дэх “бараа материалыг худалдан авсан үед: Дт-Хангамжийн материал, Кт-Мөнгөн хөрөнгө/ дансны өглөг “ гэж бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.

Хичээлийн төв байр болон дадлагын байрнуудыг халаахад зарцуулсан нүүрсийг тухай бүрд нь бус уурын зуухны механикийн сарын эцэст гаргасан тайлангийн нэгтгэсэн дүнгээр журналд бөөнөөр нь бүртгэж байгаа нь НББ-ийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

БҮЛЭГ:3

Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөө бүхий дотоод хяналт хийгдэж байна уу?

Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

3.1 Байгууллагын үйл ажиллагааны дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлсэн боловч тайлант онуудад үр дүнтэй арга хэмжээг авч, хэрэгжүүлээгүй байна.

Хөдөлмөрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус байгууллагын 2014 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаа , төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, холбогдох хууль тогтоомж, дүрэм , журмын хэрэгжилтэд дотоод аудит хийсэн байна. Аудитаар нийт 37,430.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, илэрсэн алдаа, зөрчлийг арилгах 15 зөвлөмж өгсөн байна.

Тус МСҮТ-ийн хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ажилтнаар 2016 оны 04 дүгээр сар хүртэл Б.Эрдэнэцэцэг, 2016 оны 04-р сарын 01-нээс хойш С.Дэлгэрсайханыг томилон ажиллуулсан байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан ажилтан нь жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан ажилладаг боловч хэрэгжилт нь төдийлөн хангалтгүй байгаа бөгөөд хийгдсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа, үр дүн, үр нөлөөг баримтжуулаагүй, 2015- 2017 оны хороонд уг албан тушаал хариуцсан ажилтанг 3 удаа өөрчилсөн зэрэг нь дотоод хяналтын үр нөлөөг бууруулах нөхцөл болж байна.

Аймгийн МХГ-ын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч 2016 оны 04 дүгээр сард байгууллагын нийгмийн хамгааллын чиглэлээр хяналт, шалгалт хийж бага эрсдэлтэй гэж дүгнэсэн байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих эрх, үүрэг бүхий комиссуудыг захирлын тушаалуудаар томилсон байна. Үүнд:

- 2015 оны А/23 дугаар тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр,
- 2015 оны А/17 дугаар тушаалаар ажил дүгнэх, зөвлөн туслах зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчилэн байгуулсан,
- 2015 оны А/16 дугаар тушаалаар баримт, бичгийг нягтлан шалгах комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр,
- 2015 оны А/09 тоот тушаалаар хөдөлмөрийн маргаан таслах комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр,
- 2016 оны А/07 дугаар тушаалар захирлын дэргэдэх зөвлөлийг 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчилэн баталсан,
- 2016 оны А/23 дугаар тушаалаар захирлын дэргэдэх бүрэлдэхүүнийг 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр.

Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/143, 2016 оны А/88 дугаар тушаалуудаар Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг төрийн байгууллагаас 4, төрийн бус байгууллагаас 3, сургуулийн суралцагч болон төгсөгчөөс тус бүр 1 зэрэг нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчилэн баталсан байна.

Аудитын явцад удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, гаргасан тогтоол, шийдвэртэй танилцахад 2016 онд 2 удаа хуралдаж удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийг томилох санал хүргүүлэх, ажиллах дүрэм батлах, 2015-2016 оны хичээлийн жилийн болон 2016 оны үйл ажиллагааны тайлан, багш, ажилтнуудыг шагнаж урамшуулах журмыг батлах зэрэг асуудлуудыг хэлэлцсэн байна.

Хэдийгээр санхүүгийн болон үндсэн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хэрэгжүүлэх төрөл бүрийн комисс, зөвлөл, албан тушаалтныг томилон ажиллуулж байгаа боловч тэдний зүгээс хийсэн ажил, түүний мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хүрсэн үр дүнг баталгаажуулсан баримт материалыг бүрдүүлээгүй байгаа нь хяналт, шалгалтын үр нөлөөг сулруулж, дотоод хяналт шалгалтын ажил хангалттай хэмжээгээр хийгдээгүй байна гэж үзэхэд хүргэж байна.

3.2 Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмын дагуу төсөв, санхүүгийн мэдээллийг шилэн дансны цахим сайтад байршуулж байгаа хэдий ч зарим мэдээллийг шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхой мэдээлээгүй байна.

Сэлэнгэ аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв нь Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 384, 2016 оны 29 дүгээр тогтоолуудаар шинэчилэн баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д заасан шаардлагын дагуу 2015, 2016 оны төсөв, санхүүгийн холбогдох мэдээллүүдийг www.shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудас болон мэдээллийн самбараар

мэдээлсэн бөгөөд мөн өөрийн байгууллагын www.selenge-msut.edu.mn цахим хуудсыг нэгдсэн системд шууд холбогддог байдлаар зохион байгуулсан байна.

Тус байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 15 төрлийн мэдээллийг тогтмол болон тодорхой заасан хугацаанд байршуулахаас 11 мэдээллийг хууль, журамд заасан хугацаанд байршуулж, 4 мэдээллийг дутуу болон огт байршуулаагүй байна. Үүнд:

- Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг тодорхой бүрэн оруулаагүй,
- 2015 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг оруулаагүй,
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг оруулаагүй,
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг тухай бүр өссөн дүнгээр мэдээлээгүй байна.

Илрүүлсэн зөрчил

Аудитаар дараах зөрчлүүдэд албан шаардлага бичигдлээ. Үүнд:

- Төсвийг зохистой удирдаагүйгээс болон 2014 онд төсөвт тусгаагдаж батлагдаагүй бага оврын трактор худалдан авснаас 2016 оны эцэст 5,074.4 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,
- Төсвийг зохистой удирдаагүйгээс болон батлагдсан төсөвт холбогдох зохицуулалт хийлгээгүйгээс 2015 оны эцэст 29,039.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн,
- Цалингийн зардлаас түлээ, нүүрсний хөнгөлөлтөд 2015 онд 2,320.0 мянган төгрөгийг, 2016 онд төрийн өмнөөс гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 533.6 мянган төгрөгийг зэрэг 2,853.6 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан,
- 2016 онд суралцагсдын хандив 1,867.5 мянган төгрөгийг кассаар бэлэн авч зарцуулсан,
- Багш, ажилтнуудад олгосон цалингийн урьдчилгааг бэлнээр суутгаж, 2015 онд 1,724.0 мянган төгрөгийг, 2016 онд 2,340.0 мянган төгрөгийг бусад зардалд гүйлгэн зарцуулсан,
- Захирал Д.Очирбатад 458.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалинг тогтоосон хэмжээнээс илүү олгосон,
- Хөдөлмөрийн сайдын “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын дүрэм, бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” 2016 оны А/30 дугаар тушаалыг зөрчиж байгууллагын бүтэц, орон тооны төсөвт тусгаагдаж, батлагдаагүй соёлын арга зүйч албан тушаалд Д.Тунгалагийг томилон ажиллуулж, 2,753.2 мянган төгрөгийн

цалин, шимтгэлийн зардал гаргасан зэрэг нийт **46,111.1** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичигдлээ.

Аудитын дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

- Төлөвлөсөн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж, холбогдох байгууллагуудад тайлагнаж байна.
- Төсвийн шууд захирагчийн” Үр дүнгийн гэрээ”-г төсвийн жилээр бус хичээлийн жилээр байгуулсан байна.
- 2016 оны “Үр дүнгийн гэрээ”-нд тусгасан зарим төсөл, арга хэмжээг үр дүн муутай хэрэгжүүлснээс “хангалтгүй” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.
- Суралцагсдын тоо, төсвийн зардлыг бодит байдлаас хэт өндрөөр төсөөлөж, хүргүүлснийг төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд танаж, баталсан байна.
- Төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой хууль, эрхийн актыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Батлагдсан төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүсгэж, цалингийн зардлаас бусад зардалд гүйлгэн зарцуулсан байна.
- Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээлвэл зохих мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Удирдах зөвлөлийн дарга, гишүүдэд:

- Удирдах зөвлөлийн 2016 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “ Сэлэнгэ аймаг дахь мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн удирдах зөвлөлийн дүрэм”-ийн 3.1-д заасан чиг, үүрэг үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх.
- Захирлын үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт, дүгнэлт болон бусад үйл ажиллагааг хурлын тэмдэглэл зэрэг бусад холбогдох баримт материалаар баримтжуулж, архивлан хадгалах.

Захирал Д.Загдгочоо, нягтлан бодогч Л.Баасанжав нарт:

- Үр дүнгийн гэрээг Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн жилээр байгуулж байх.
- Төсвийн тухай хууль болон холбогдох журмуудыг мөрдөн ажиллаж, цалингийн зардлаас бусад зардалд гүйлгэн зарцуулахгүй байх,

- Төсвийг зохистой удирдаж, жилийн эцэст өглөг, авлага үүсгэхгүй байх зарчмыг баримталж ажиллах.
- Цалингийн зардлыг холбогдох хууль, журам, зааврын дагуу зарцуулж байх.
- Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах.
- Төсөв, санхүүгийн холбогдох мэдээллүүдийг шилэн дансны цахим санд бүрэн байршуулж байх.

Эд хариуцагч. А.Эрдэнэцэцэгт:

- Нүүрсний зарцуулалтыг сарын нэгтгэсэн дүнгээр бус тухай бүрийн гүйцэтгэлээр нь журналд бүртгэж, зарцуулалт болон үлдэгдэлд тавих хяналтыг сайжруулах.
- Хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас сургалтад хэрэглэгдэхээр худалдан авсан материалын орлого, зарлагыг бараа материалын дансаар дамжуулж, зарцуулалтын үр дүнг тооцож байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
ШИНЖЭЭЧ



Ч.ӨНХТУЯА
Б.БАТМӨНХ
С.БАТ-ЭРДЭНЭ
Ж.ЦОГТ

**СЭЛЭНГЭ АЙМАГ
МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/факс: 7036-2371

2017.06.29 № 117


танай _____-ны № _____-т

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Сэлэнгэ аймаг дахь МСҮТ-ийн үйл ажиллагааны үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Цаашид аудитын газраас гаргасан зөвлөмжийн дагуу зөрчил дутагдал өр авлага гаргахгүй байх талаар онцгой анхаарч ажиллах болно.

ЗАХИРАЛ



Д.ЗАГДГОЧОО

6000 62